

“БИЧИГТ ШИМ МАЙНИНГ” ХХК

**“БИЧИГТ ШИМ МАЙНИНГ ” ХХК -ИЙН СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦАГААН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ
“ХӨНДЛӨНГИЙН ӨНГӨЛГӨӨНИЙ БОРЖИН ЧУЛУУНЫ ОРД”-
ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ
РД: 6690912**

ГАРЧИГ

ОРШИЛ.....	2
I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
III ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	13
IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	15
V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	17
V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
V.2 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
V.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	21
V.4 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	21
V.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
V.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	23
V.7 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө.....	25
V.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	27
V.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	28
V.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	29
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга.....	3
Хүснэгт 2. Уурхайн солбилцол.....	3
Хүснэгт 3. Багийн өрхийн мэдээлэл, хүн ам.....	10
Хүснэгт 4. Багийн малчин өрхийн тоо	12
Хүснэгт 5. Сумын мал аж ахуйн үзүүлэлтүүд.....	12
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
Хүснэгт 7. Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал.....	29

ОРШИЛ

“Бичигт шим майнинг” ХХК-ийн өнгөлгөөний боржин чулууны ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ –нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээний төлөвлөгөөт ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 9.394 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Үйл ажиллагааны хүрээнд уурхайн бэлтгэл ажлууд, ХАБ-ын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, Батноров сумын ЗДТГ-тай байгуулсан нийгмийн хариуцлагын ажлуудыг хийхээс гадна байгаль орчны болон хүний эрүүл мэндийг хамгаалах, уурхайн бүс нутгийн оршин суугчид руу чиглэсэн нийгмийн сайн сайхны төлөө ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Уурхайн 2025 онд хэрэгжүүлсэн БОМТ-г боловсруулахад байгаль орчны судалгаа, үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “ТӨГРӨГ БАЯН ХАНГАЙ” ХХК-аас мэргэжлийн зөвлөгөө авсан бөгөөд төлөвлөгөөг БУАӨЯ-наас 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд төлөвлөлтийг тус журмын 1 дугаар хавсралтын “А”-д заасан агуулгаар боловсруулсан болно.

БОМТ-г нийт 5 бүлэг, 13 дэд бүлэгт багтаасан байна.

I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөвлөгөөний нэр: “Хөндлөнгийн өнгөлгөөний боржин чулууны орд”-ын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Бичигт шим майнинг” ХХК

Төслийн зорилго: Уг ордыг ашиглан боржин чулууг олборлон борлуулснаар улсын болон орон нутгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах зэрэгт энэхүү төслийн зорилго оршиж байна.


Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Бичигт шим майнинг” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9011826706
3	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Сүхбаатар
4		Сум/Дүүрэг	Эрдэнэцагаан
5	Ашигт малтмалын төрөл		Боржин чулуу
6	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-022389
7	Ашиглалт эхэлсэн огноо		2025
8	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
9		Сум/Дүүрэг	Чингэлтэй
10		Баг/Хороо	3-р хороо
11		Гудамж/Байр	40,50 мянгат, 34-р байр, 704 тоот
12		Гар утас	99104510
13	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал Б.Батцэцэг
14		Гар утас	99104510

Төслийн байршил: “Бичигт шим майнинг” ХХКомпаний MV-022389 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах ба Улаанбаатар хотоос 850 орчим км-т, Баруун-Урт хотоос зүүн урагш 270 орчим км-т, Эрдэнэцагаан сумын төвөөс урд зүгт 50 орчим км-т, Бичигтийн хилийн боомтоос зүүн хойш 70 орчим км-т тус тус байрлах бөгөөд байр зүйн зургийн L-50-88 гэсэн хавтгайд оршино.

Хүснэгт 2. Уурхайн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	115° 29' 3"	45° 27' 10"
2	115° 28' 17"	45° 27' 10"
3	115° 28' 17"	45° 28' 0.03"
4	115° 29' 3"	45° 28' 0.03"



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг

Ил уурхайн хүчин чадал

Уурхайн жилийн хүчин чадлыг тус байгууллагын даалгаврын дагуу жилд дунджаар 180-400 мян.м³ чулуу олборлон боловсруулахаар ТЭЗҮ-д тусгасан байна. Цаашид өнгөлгөөний боржингийн чанарыг сайжруулахад анхаарч ажиллах бөгөөд борлуулалтын байдлаас хамааран хүчин чадлыг өсгөх бүрэн боломжтой юм.

Ашиглалтын блокийн дугаар	Ү нөөц	Х нэгж	Ашиглалтын жилүүд										Нийт
			1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	6-р жил	7-р жил	8-р жил	9-р жил	10-р жил	
B ^I -1	436.270	мян.м ³	161.4	119.6	100.3		54.86						436.2
B ^I -2	489.171	мян.м ³		161.4	63.59		76	188					489.1
B ^I -3	461.992	мян.м ³		69.30	157.08			162.38	73				461.9
B ^I -4	669.990	мян.м ³				328			277	64.5			670
B ^I -5	884.238	мян.м ³				22	212			286	291.91	72.2	884
B ^I -6	285.725	мян.м ³	28.6	28.6	28.6	28.6	28.6	28.6	28.6	28.6	28.6	28.6	285.7
B ^I -7	116.931	мян.м ³									58.5	58.5	117
B ^I -8	210.530	мян.м ³	21.05	21.1	21.1	21.1	21.1	21.1	21.1	21.1	21.1	21.1	210.5
B ^I -9	73.014	мян.м ³	36.5		29.36		7.14						73.01
Нийт	3,627.86	мян.м ³	247.5	400	400	400	400	400	400	400	400	180	3,627.8

Уурхайн ашиглалт нь улирлын чанартай ажил бөгөөд хөрс хуулалт, боржин чулуу олборлолт, борлуулалтын ажлыг сонгон авсан техник, тоног төхөөрөмж, уул техникийн нөхцлийг харгалзан уртасгасан хугацаагаар ажиллана. Хөрс хуулалт болон боржин чулуу олборлолтын ажил нь 7 хоногоор тасралтгүй ажиллах бөгөөд хоногт 2 ээлжээр ажиллах ба нэг ээлийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна. Уурхай нь 350 хоног ажиллана. Уурхайд нийт 116 хүн ажиллана.

II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ландшафт: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг нь физик газарзүйн мужлалаар Монгол Дорнод талын их муж, Халхын дундад ба Дарьгангын талархаг муж, Дарьгангын тэгш өндөрлөг талархаг тойрогт хамаарагдах бөгөөд гадаргын ерөнхий тогтоц нь нам бэсрэг уулс, тэдгээрийн хоорондох хөндий, толгодорхог тал хөндий, зарим хэсэгтээ нам хотосын шинжтэй өргөн хөндийнүүдээс бүрддэг.

Уур амьсгал, агаарын чанар: Өнгөлгөөний боржингийн ордын талбай орчмын газар нутаг нь ерөнхийдөө дулаан уур амьсгалтай, хур чийг багатай бөгөөд эндэхийн уур амьсгалд өвлийн цагт эсрэг циклон, зун баруун зүгээс орж ирдэг циклон ихээхэн нөлөөлдөг.

Зүүн өмнөд хэсэгт БНХАУ болон Монгол Улсын нутаг дэвсгэрт үргэлжлэн орших Их Хянганы салбар уулс, Эрдэнэцагаан сумын орчим зүүн ба зүүн өмнөд захаар муссон салхины үйлчилгээ мэдэгдэхүйц байдаг байна.

Өвлийн улиралд гэнэтийн дулааралт бараг ажиглагддаггүй бол зуны улиралд гэнэтийн хүйтрэлт хааяа тохиолдоно. Агаарын температурын бас нэг онцлог бол хавар, намрын улирал богинохон, халуун хүйтний солилцоо эрс байдаг явдал юм.

Эрдэнэцагаан сумын нутаг өндөр уул нуруу хонхор багатай газрын гадаргын хэв шинж бараг нэг төрлийн жигд байдаг учраас байгалийн ба уур амьсгалын нөхцөл нь онцын ялгаагүй уур амьсгалын голлох үзүүлэлт хур тунадас температур ургамлын ургалтын хугацааны чийгийн хангамжийн үзүүлэлтийг уур амьсгалын мужлалын гол үзүүлэлт болгон авч болно. Тус сумын нутаг дэвсгэрийг уур амьсгалын хувьд дараах байдлаар мужлав. Үүнд:

- Чийглэгдүү сэрүүвтэр
- Хуурай дулаавтар
- Нэн хуурай дулаан

Усан орчин:

Гадаргын ус: Судалгааны талбай болон түүний ойр орчны нутаг дэвсгэрт байнгын урсацтай гол, горхи байхгүй, зөвхөн Эрдэнэцагаан сумын төвийн ойр орчимд хэд хэдэн жижиг гол урсах боловч сэвсгэр хурдсанд шингэдэг онцлогтой. Тийм голын тоонд Чоно гол, Ханын гол зэрэг орно.

Харин талбайн ойролцоо жижиг булаг, шанд, нуур, цөөрөм байдаг. Тэдгээр нь голчлон талархаг газрын хагас хонхорт тогтсон байх ба хур бороотой үед устай байдаг боловч гандуу болоход ууршиж хэмжээ нь багасдаг буюу хужир, марз, тойром болж бүрмөсөн ширгэдэг. Сүүлийн жилүүдэд эдгээр нуур, цөөрмүүдийн ихэнх нь ширгэж байгаа нь уур амьсгалын өөрчлөлт, дулааралтай холбоотой гэж үзэж болно. Гэхдээ бороо, хур их орсон үед ширгэсэн жижиг нуур, цөөрөм, булаг, шанд сэргэх явдал ажиглагдаж байна.

Газрын доорх ус

Судалгааны талбай дахь “Хөндлөн” нэртэй өнгөлгөөний боржингийн орд газар нь Монгол орны гидрогеологийн мужлалаар гидрогеологийн өмнөд системийн Мэнэнгийн талын сав газрын газар доорхи усны нөөц зонхилсон “Тамсаг-Мэнэнгийн” дэд мужийн өмнөд хэсэгт оршдог. Энэхүү сав газарт ашиглах бололцоотой газар доорхи усны нөөц гэдэг нь олон жилийн туршид хуримтлагдсан газар доорхи усны нөөцөөс бүрддэг ба ашиглах

бололцоотой нэгж талбай дахь газар доорхи усны нөөц нь сав газарт 0.003-1.0 л/с/км.кв байдаг.

Судалгааны талбай нь 1300-1600 м үнэмлэхүй өндөртэй баруун хойноосоо зүүн урагшаа чиглэлтэй урт хөдийгөөр хэрчигдсэн нэгэн хэвийн намхан бэсрэг уул толгодорхог, усан сүлжээ муу хөгжсөн Нүхт давааны өргөгдөлд хамаарагдана.

Хөрсөн бүрхэвч: Хөрсний химийн найрлагын хувьд нийт үе давхаргадаа сул шүтлэгээс дунд зэргийн шүтлэг урвалын орчинтой байна. Ихэнх таримал ургамалд хөрсний орчин (pH) сул хүчиллэгээс сул шүтлэг орчин буюу 6.5-8.0 байхад тохиромжтой байдаг. Хөрсний бүхий л үе давхаргад карбонатгүй байна. Цахилгаан дамжуулах чанар буюу давсны агууламжаар төдийлэн ихгүй тохиромжтой түвшинд байна. Бүх зүсэлтэд хөрсний 0-30 орчим см-ын үе давхрагад ялзмагын бодисын агууламж тохиромжтой байгаа боловч доод үеүдэд огцом биш бага зэрэг багасч байгаа нь хөрсний үржил шим сайн байгааг илтгэнэ. Ургамалд ашиглагдах хөдөлгөөнт фосфор, калийн хангамж мөн дээд үедээ тохиромжтой, доошлоод бага байна. Механик бүрэлдэхүүний хувьд нийт үедээ буюу хөрсний 0-60 см хүртэл хөнгөн шавранцар болон элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байгаа хэдий ч физик шаврын хэмжээ 15 %-иас дээш байгаа нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрстэй ойролцоо байна. Хөрс нь хүнд металлын бохирдолгүй байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин сайн.

Ургамлан нөмрөг: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт хэрэгжихээр төлөвлөж буй төслийн талбай орчны нутаг дэвсгэр нь ерөнхийдөө чулуурхаг хээрийн шинжийг илтгэсэн хиаг-үетэнт бүлгэмдэл бүхий бэлчээрийн хэв шинжтэй бөгөөд хааяа нэг шингэн дэрс энд тэнд ургасан байх нь ажиглагдлаа.

Энэ бүлгэмдэлд мөлхөө хиаг, дэрс, биелэг, саман ерхөг, улалж зэрэг зүйлийн ургамлууд зонхилон ургаснаас гадна тухайн жилийн улирлын онцлогоос хамаараад ургамлан нөмрөгийн бүрхэц, биомасс нь янз бүр байна. Тухайн нутаг дэвсгэр нь малчдын бэлчээрийн зориулалтаар ашиглагддаг тул бэлчээрийн талхлагдалд бага зэрэг өртсөн боловч антропоген болон техноген нөлөөлөлд өртрөөгүй, элдэв мэргэгчид, хортон шавжид идэгдээгүй байна.

Харин тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд тээвэрлэлтийг нэг замаар хийгээгүй, олон салаа зам гарган хүссэн замаараа явж байгаа нь ургамлан нөмрөгийг устаж доройтуулах нэг шалтгаан болдог байна. Тухайн зам гаргасан талбайд ургаж байсан ургамлан нөмрөгийг устгаж доройтуулах сөрөг нөлөөг үзүүлэхээс гадна шороон замаас их хэмжээний тоосжилт үүсэж байгаа нь ургамлан нөмрөгийг доройтуулж байна.

Амьтан: Эрдэнэцагаан сумын Далай булаг, Баянцагаан, Хөхтийн нуруу орчмын хөхтөн амьтдаас 5 зүйл буюу нийт хөхтний 20 орчим хувь нь Монгол Улсын болон олон улсын хэмжээнд ямар нэгэн хэлбэрээр хамгаалсан статустай байна. Тухайлбал, нийт хөхтний 4 хувийг Монгол Улсын “Улаан ном-д бүртгэлтэй дагуур зараа, 7 хувийг “Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн (CITES) II хавсралтанд бүртгэлтэй саарал чоно, мануул, мөн 7 хувийг “ховор” катигорт оруулан хамгаалсан Лхачинвандад ууланд цөөвтөр нутагладаг халиун буга, 42 хувийг агнуурын ач холбогдолтой амьтад эзлэж байгаа юм.

Энэ нутагт тархсан 27 зүйл шувуудын 75 хувь жилийн аль ч улиралд тэндээ суурин нутагладаг, 25 хувь нь нүүдлийн шувууд байна. Эдгээрээс шувуудаас агнуурын ач холбогдолтой нүүдлийн ангир, анхидал, суурин ногтруу, дагуур ятуу гэх 4 зүйл жигүүртэн энэ нутагт ховор тохиолдоно. Харин шилийн сар, идлэг шонхор, сохор элээ, шар шувуу, хотны бүгээхэй зэрэг 5 зүйл шувуу Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцийн 2-р хавсралтанд бүртгэн авч хамгаалсан байна. Эдгээр хамгаалсан шувууд нь энэ нутгийн нийт жигүүртний 17,8 хувийг эзлэж байна.


Энэ нутгийн экологийн үндсэн биотопыг дагаж уул толгод, тал хээрийн шувууд зонхилж, суурин газрын шувууд нэлээд хувийг эзлэж байна.

Хээрийн судалгааны ажлын үед судалгааны талбайд болон түүний ойр орчимд Хөхтөн амьтадаас халиун, буга, цагаан зээр элбэг тааралдсан болно.

Тусгай хамгаалалттай газар нутаг: Дорнод Монголын дархан цаазат газар нь Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт нийт 570.3 мян.га талбайг хамрах ба үүнээс Эрдэнэцагаан сумын нутагт 120.1 мян.га талбай нь оршдог байна. Энэ газрыг Дорнод Монголын хялганат талын экосистем, цагаан зээрийн байршил нутгийг хамгаалах зорилгоор УИХ-ын 26-р тогтоол /1992 онд УБХ-ын 11-р тогтоол/-оор Дархан цаазат газрын ангиллаар УТХ-нд авсан байна.

Дорнод Монголын дархан цаазат газарт Монгол орны цагаан зээрийн 70 гаруй хувь нь идээшилж амьдардаг ба Монголын Дорнод тал төдийгүй Ази тивийн хуурай хээрийн унаган төрхийг хадгалж буй тал хээрийн иж бүрдлийг төлөөлөх газар юм.

Тус нутагт Монгол улсын улаан номд орсон Дорнодын сармаахай, дагуурын зараа зэрэг хөхтөн, хошуу галуу, гангар хун, цэн тогоруу, тоодог, азийн цууцаль гэх мэт шувууд бүртгэгдсэн байна. Судалгааны талбай нь улсын болон орон нутгийн ДЦГ, ДГ, БЦГ-т хамаарахгүй боловч судалгааны талбайн зүүн талд 4.6 км Лхачинвандад уул хэмээх БНГ оршдог.



Зураг 2. Судалгааны талбай ба БНГ-ын байршил

Лхачинвандад уулыг эрт дээр үеэс дархлан хамгаалж байсан түүхтэй бөгөөд анх 1965 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн 17-р зарлигаар ДЦГ болгож, 1998 онд УИХ-ын 26-р тогтоолоор байгалийн өвөрмөц хэв шинжтэй, ховор ховордсон ургамал амьтад болон буга амьдрах орчныг хамгаалах зорилгоор байгалийн нөөц газарт авсан юм.

Тус байгалийн нөөц газар нь Эрдэнэцагаан сумын зүүн урд хэсэгт 57.9 мян.га газрыг эзлэн оршино.

1886 онд Егүзэр хутагт Ж.Галсандаш Өвөр Монголын Хянганы орчмоос ирүүлсэн буга согоог анх энэ нутагт бойжуулан маллаж 1905 оны үед 20 гаруй, 1915 оны үед 100 орчим толгойд хүрэхэд нь хашаа хамгаалалтаас гаргаж байгальд нь тавьсан байна.

Хутагтын нутагшуулсан амьтдын дотор зөвхөн буга төдийгүй тарвага, шар үнэг, хярс, мануул, илбэнх зэрэг ан амьтан байжээ. Үүнээс одоогоор буга, тарвага нь үлдсэн бөгөөд хамгийн их тархсан туурайтан нь цагаан зээр юм.

Энэхүү Лхачинвандад уул хэмээх БНГ-т идэш тэжээл, амьдралын нөхцөл, хэлбэрээр бие биетэйгээ холбогдсон нэгийг нь нөгөөгөөс нь үл салгаж болох 180 гаруй зүйлийн дээд ургамал, 20 зүйл хөхтөн амьтан, 49 зүйл шувуу бүртгэгдсэн ба үүний 19 нь суурин амьдралтай, 30 гаруй нь нүүдлийн шувууд байна. Эдгээрээс дэлхийн хэмжээнд ховорт тооцогддог тоодог, устах аюулд орж болзошгүй тас, Монгол улсын “Улаан ном”-д бүртгэгдсэн явлаг сар зэрэг шувууд, мөн олон зүйлийн шавьж хорхой, бичил биетэн оршин амьдардаг.

Ордыг ашиглах үндсэн үйл ажиллагаа нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 21-р зүйлд заасан Байгалийн нөөц газрын дэглэмийг зөрчихгүй боловч БНГ-ын ойролцоо үйл ажиллагаа явуулах тул энэ хуулийн Байгалийн нөөц газрын дэглэмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй аюул осол, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.

Монгол улсын хилийн тухай хуулийн 26-р зүйлд Улсын хилийн зурвас, түүнд мөрдөх журам, хориглох зүйлийг тодорхойлсон байна. Уг зүйлд улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ гэж заасан байна.

Өнгөлгөөний боржингийн ордын талбай нь хилийн зурвас нутаг дэвсгэрт оршиж байгаа тул хилийн зурваст мөрдөх журмыг нарийн чанд баримтлан ажиллаж хилийн зурваст явуулахыг хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх шаардлагатай.

Хилийн цэргийн 0146-р анги нь Эрдэнэцагаан сумын төвд байрладаг тул төсөл хэрэгжүүлэгч нь тухайн талбайд явуулах үйл ажиллагааныхаа талаар мэдээллээ цаг тухайд нь өгч тус ангитай уялдаа холбоотой ажиллавал зохино.

Түүх соёлын дурсгалд газрууд: Энэхүү судалгааны талбай болон түүний ойр орчимд түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйл болон археологийн ба палеонтологийн олдвор, булш, хирэгсүүр тогтоогдоогүй.

Нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Эрдэнэцагаан сум

Нутгийн хилийн нийт урт 1340 км бөгөөд урд талаараа БНХАУ-тай 485 км, баруун талаараа Дорноговь аймагтай 165 км, хойт талаараа Хэнтий аймагтай 260 км, зүүн хойт талаараа Дорнод аймагтай 430 км газраар тус тус хиллэдэг.

Аймгийн нутаг Дорнод Монголын тэгш талын өмнөд хэсгийн үргэлжлэл бөгөөд нийтдээ 82.3 мян.км² газар нутагтай, тал хээрийн бүсэд багтдаг. Нутгийн ихэнх хэсэг нь далайн түвшнээс дээш 1000 1200м өндөрт оршдог. Хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1778 м-т өргөгдсөн Шилийн Богд уул, хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 790 м-т өргөгдсөн Байшинт юм.

Байгалийн сонин тогтоц бүхий газар нутаг элбэгтэй. Үүнд: Дарьганга суманд 200 гаруй сөнөсөн галт уул, Онгон Дарьганга суманд 127-248 км² талбай эзлэх Онгон, Молцогийн их элс, Эрдэнэцагаан сумын нутагт байгалийн нөөц газар Лхачинвандад уул, Дарьганга, Наран сумын нутагт Баяндулаан, Талын агуйт, Мөнххаан сумын Баян-Уулын орчмын агуй зэрэг юм.



Сум байгуулагдсан түүх: 1924 оны 4 дүгээр сард Улсын бага хурлын шийдвэрээр Эрдэнэцагаан уулын хошуу нэртэйгээр анх байгуулагджээ. Аймгийнхаа хамгийн зүүн өмнөд хязгаарт, 17,3 мянган км.кв газар нутагтай. Тус суманд Хөндлөх хайлааст, Цагаан-Овоо, Бадрах, Хонгор, Билүүт, Жаргалант, Хадынбулаг, Алтан-Овоо гэсэн 8 багийн 6,970 хүн амьдарч байна. Халх, хуучид, үзэмчин, дарьгангачууд амьдардаг.



Газар зүйн байршил: Газар нутаг нь тал хээрийн бүст багтана. Дархан цаазат Лхачинвандад уул, Зотол хаан, Уртын цагаан овоо, Норов уул, Бяруутын баян цагаан, Чандмань уул зэрэг уулстай. Хөндлөн Хайлааст, Хэцүүгийн ам, Яам хад, Баян хайлс, Мойлтын өндөр зэрэг үзэсгэлэнт газар олонтой. Хонгор, Жаргалант, Хад, Могойн гол, Усан хөд, Чоно гол зэрэг 20 гаруй булаг, горхитой. Рашаан Цайдам, Далай булаг зэрэг рашаан устай.

Хонгорын голын алт, Чоноголын гянт болд, Нүхтийн молибден, Баянцогтын нүүрсний орд газартай. Сумын төв нь Чоно гол. Баруун-Уртаас 217 км, Улаанбаатараас 777 км зайтай.

Газар ашиглалтын байдал: Эрдэнэцагаан сум нь аймгийнхаа хамгийн зүүн өмнөд хязгаарт орших бөгөөд 1694.8 мянган га газар нутагтай, түүний дотор хөдөө аж ахуйн эдэлбэр газар 1421.0 мянган га, тусгай хамгаалалттай газар 271.1 мянган га, усны эдэлбэр газар 545 га, зам сүлжээний газар 1542.2 га, хот суурингийн эдэлбэр газар 577.4 га-г тус тус эзэлдэг.

Газар тариалан: Газар тариалангийн үйлдвэрлэл хөдөө аж ахуйн нэгдэл тарснаас хойш зогсонги байдалд орсон. Сүүлийн жилүүдэд өрхийн төмс, хүнсний ногооны тариалалт жилээс жилд нэмэгдэж, иргэдийн идэвх санаачлага дээшилж, хүлэмжийн тариалалт хийж байна. Усалгаатай тариалан эрхлэхэд усны хангамж хүрэлцээгүй тул нэгжээс авах ургацын хэмжээ бага байдаг. Хадлангийн талбай хүрэлцээтэй, ургац сайн ч техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу тул газар тариалан зогсонги байдалтай байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ: Үйлдвэр үйлчилгээний хувьд талх, нарийн боовны цех нэг, блокны үйлдвэр 2 ажилладаг. Худалдаа, үйлчилгээний 43 цэг, салбар байдаг ба энэ нь

бөөний худалдааны цэг, супермаркет, минимаркет, баар, цайны газар, кафе, мах, сүү, цагаан идээний дэлгүүр, хүнс, бараа, барилгын материал, сэлбэгийн дэлгүүр ажилладаг. Ахуйн үйлчилгээний салбарт үсчин 4, гуталчин 1, зочид буудал 4, оёдолчин 3, мужаан 4, машин, мотоциклын засвар, дугуй засварын газрууд тус тус ажилладаг.

Дэд бүтэц: Эрчим хүчний төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон ба нар, салхины эх үүсгүүр ашигладаг өрхийн тоо 700 орчим болоод байна.

Аймгийн төв болон бусад сумдтай шороон замаар холбогддог. Сумын төвд 3 км хатуу хучилттай замтай. Сумаас гадагш болон доторх ачаа, зорчигч тээврийн үйл ажиллагааг хувийн хэвшлийнхэн гүйцэтгэдэг. Аймгаас суманд 7 хоногт 2 удаа шуудангийн үйлчилгээ үзүүлдэг, багуудад шуудан хүрдэггүй.

Дэд бүтцийн хөгжил төдийлөн сайнгүй. Байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын дурсгалт газруудаа түшиглэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нөөц боломжтой.

Байгалийн баялгийг нь ашиглаад нөхөн сэргээлт хийхгүй байх асуудал байсаар байна. Сумын төв орчимд ногоон байгууламж байхгүй, шороон шуурга ихэссэн, усны нөөц багассан зэрэг нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх талтай.

Өнгөлгөөний боржингийн ордын талбай нь Эрдэнэцагаан сумын 3-р багийн нутаг дэвсгэрт харьяалагдаж байна.

Эрдэнэцагаан сумын 3-р баг нь 200 гаруй өрхийн 700 орчим хүн амтай. Багийн иргэдийн амьжаргааны гол эх үүсвэр нь мал аж ахуйн салбар. Тус багийн нутаг дэвсгэрт “Бадмаараг хаш”, “Андын илч” ХХК-иуд нүүрс олборлох үйл ажиллагаа явуулж байна.

Сумын статистик мэдээ:

Хүснэгт 3. Багийн өрхийн мэдээлэл, хүн ам

Сум, баг	Хүн амын тоо					Өрхийн тоо				
	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2019 Он	2020 Он	2021 Он	2022 Он	2023 он
1-р баг, Хөдлөн хайлааст	1,029	1,055	1,096	1,117	1,172	85	89	98	06	19
2-р баг, Цагаан овоо	1,081	1,111	1,100	1,091	1,091	00	04	27	25	18
3-р баг, Бадрах	709	731	735	762	748	85	98	04	14	23
4-р баг, Хонгор	613	627	676	694	677	64	70	81	85	86
5-р баг, Билүүт	1,000	990	960	887	828	64	68	58	39	37
6-р баг, Жаргалант	721	727	745	752	755	03	13	22	35	36
7-р баг, Хадын булаг	767	784	798	833	845	20	31	42	51	58
8-р баг, Алтан овоо	848	868	855	838	846	47	59	61	56	54
Эрдэнэцагаан	6,768	6,893	6,965	6,974	7,062	868	932	993	1,011	1,031




График 1. Өрхийн тоо 2019-2023 он




График 2. Хүн амын тоо 2019-2023 он

Эрдэнэцагаан сумын хүн амын өсөлт 1%-тай, тус сумын хүн амын тоо сүүлийн 5 жилд буурсан үзүүлэлтгүй байна. 2023 оны байдлаар нийт 2031 өрхтэй бөгөөд үүний 1069 буюу 53.1 хувь нь малчин өрх байна.

Хүснэгт 4. Багийн малчин өрхийн тоо

Сум, баг	2024 он
1-р баг, Хөндлөн хайлааст	230
2-р баг, Цагаан овоо	51
3-р баг, Бадрах	191
4-р баг, Хонгор	162
5-р баг, Билүүт	44
6-р баг, Жаргалант	179
7-р баг, Хадын булаг	217
8-р баг, Алтан овоо	57
Эрдэнэцагаан	1131

Тус сумын малын тоо толгой 2024 оны байдлаар 367736 бөгөөд үүнээс хонь 39.3 хувь буюу 144677, ямаа 36.6 хувь буюу 134421, үхэр 8.5 хувь буюу 31360, адуу 15.4 хувь буюу 56698, тэмээ 0.2 хувь буюу 580 тоо толгой бүхий байна.(График 3, Хүснэгт 5,)

Хүснэгт 5. Сумын мал аж ахуйн үзүүлэлтүүд

Сум, баг	Адуу		Үхэр		Хонь		Ямаа		Тэмээ		ийт
	оо толгой	злэх хувь	оо толгой	злэх хувь	оо толгой	злэх хувь	оо толгой	злэх хувь	оо толгой	злэх хувь	оо толгой
Эрдэнэцагаан	6698	5.4	1360	.5	44677	9.3	34421	6.6	80	.2	67736

Малын төрөл тус бүрээр эзлэх хувь, 2024 он




График 3.Малын төрөл тус бүрээр эзлэх хувь, 2024 он

/ Эх сурвалж www.1212.mn/

III ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг нь физик газарзүйн мужлалаар Монголын дорнод талын их муж, Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн Дарьгангын талархаг газрын тойрогт хамаарагдана.

Ил уурхайгаас гадаад овоолгод буулгах хөрсний хэмжээ цулаар 920 мян.м3, сийрэгжисэн хөрсний эзэлхүүнээр 1109 мян.м3 байна. Үүнээс шимт хөрсний овоолго нь 136 мян.м3 овоолго үүсэхээр байна.

Уурхайгаас гарах хаягдал гадаад, дотоод овоолго үүсгэх байдлаар төлөвлөсөн. Хөрсний гадаад овоолгод буулгах хөрсний хэмжээ нийт 1109 мян.м3 Овоолго дахь чулуулгийн сийрэгжилт 1.2 байх ба овоолгын замын налуу нь 87%, овоолгын замын өргөн 10 метр байна.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Технологийн хийн хаягдал - Энэ үзүүлэлт нь технологийн автотээврийн түлшний зарцуулалт, хөдөлгүүрийн ажлын горимоос хамаарна. Тус уурхайд дизель түлшээр ажиллах бульдозер, ачигч, автосамосвалууд, түлшний автоцистерн, зэрэг механизмууд ашиглагдах ба судалгааны материалаас үзэхэд тэдгээрийн утааны яндангаар 1 тн дизелийн түлшний шаталтаас үүсэх хорт хий нь $CO-0.1г /0.0000001 тн/$, нүүрстөрөгч— $0.03г /0.00000003 тн/$, $NO_2-0.04г/0.00000004 тн/$, $SO_2-0.02г //0.00000002 тн/$, хөө-15.5кг /0.0155тн/, бензопирин-0.32г /0.00000032 тн/, гэж тогтоожээ.

Уурхай ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт 902.8 тонн дизель түлш зарцуулахад хөө – 13.9 тн, $CO-0.00009028 тн$, нүүрстөрөгч-0.000027084 тн, $NO_2-0.000036112 тн$, $SO_2-0.000018056 тн$, бензопирин-0.000288896 тн буюу нийтдээ 13.90 тн хорт хий ялгарахаар байна.

Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гүний усанд шууд нөлөөлнө.

Технологийн процесс, тоосжилтыг дарахад ашиглах усыг гүний худгаам хангах тул усны нөөцөд бага хэмжээний өөрчлөлт оруулна.

Газрын доорх болон гадаргын усан орчин бохирдсон тохиолдолд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлнө.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсөнд шүлтлэг металлын агууламж нэмэгдэж, хөрсний кали, фосфорын элементүүд багасаж улмаар бүрхүүлд нөлөөлж ургамал эрт хагдрах, хөрс элэгдэх үндсэн шалтгаан болдог. Судалгаанаас үзвэл газарт бууж буй тоос нь ургамлын аль нэг хэсэгт наалдаж улмаар өнгө зүс нь алдагдах, навч шилмүүсэнд нь түлэгдэлт үүсэх, навч нь эрт унах зэрэг байдал бий болдог байна.

Ургамлын бүрхүүлийн энэхүү өөрчлөлт нь хүний нүдэнд ил харагдаж байдаг бол үүний цаана нүдэнд харагдахгүй ихээхэн өөрчлөлт орох, фотосинтезийн идэвхи буурах, өсөлт удаашрах улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих зэрэг байдал бий болдог байна. Иймээс уурхайн эдэлбэр газрын гадна орших талбайн хөрс, ургамлын бүрхүүлийг тоосонд дарагдахаас хамгаалахад анхаарч ажиллах нь зүйтэй.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй.

Эерэг нөлөөллийн хувьд амьтны аймгийн мониторинг нь энэ бүс нутаг орчмын амьтны хотын тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангах чухал ач холбогдолтой.

Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх сөрөг нөлөөлөл: Тус төслийн талбайд хийсэн палентлогийн хайгуул судалгааны үр дүнд олдвор олоогүй байна.

Археологийн авран хамгаалах хайгуулын судалгааны үр дүнд энэхүү талбайгаас 17 дурсгал илрүүлэн баримтжуулсан бөгөөд шоргоолжин булш 6, улаан зуух хэлбэрийн булш 5, Монгол булш 5, чулуун байгууламж 1 хэмээн тодорхойлсон байна.

Эртний түүхийн дурсгал талбайн зүүн хойд хэсгийн Суман өндөр уул болон түүний орчны бүсээр таруу оршилттой тархсан нь хайгуулын судалгааны явцад тодорхой болсон байна.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Төслийг хэрэгжүүлэхэд ажиллах хүчинг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөтэй. Харин төсөл хэрэгжиж дууссаны дараа уурхайд ажиллаж байсан хүмүүсийн ажил эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэхгүй орхивол ядуурал, ажилгүйдэл нэмэгдэж сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Мөн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг нийгэм эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай.

Уурхайн ажлын үед ашиглаж буй техник, машин механизмаас дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн ам, ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Орон нутгийн оршин суугчдын эдийн засгийн үзүүлэлтүүд, худгийн түвшин, бэлчээрийн доройтол, малын тарга хүч буурах зэрэг нөлөөллүүд үүсэх болно.

Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл: Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах,

шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОУАӨЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-ний тайланг боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тус төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул эрсдэлийг гаргахгүй байх тал дээр зорилт тавин ажиллаж байна.

Дүйцүүлэн хамгааллын стратеги	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар 08	Сар 09	Сар 10		
	1	2	3	4	5	6	7
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам 2025 оныг хөв цөөрөм байгуулах жил болгон зарлаж, 333 нуур, "1 сум-1 нуур" уриалга	Хөв цөөрөм байгуулах, эко хашаа байгуулах,	2000.0	захиалга	хүлээлцэх	хүлээлцэх	ХАБЭА	
Биотехникийн арга хэмжээ	Багийн түвшинд орон нутгаас чиглэл өгсөн газарт зэрлэг амьтдад зориулж өвс хужир мараа тавьж өгөх, орон нутгийн байгаль хамгаалагчтай хамтран ажиллах	2000.0	захиалга	хүлээлцэх	хүлээлцэх	ХАБЭА	
	Нийт	4000.0					

V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үйл ажиллагааны үе шатанд	Агаарын чанар	Ордыг ил аргаар олборлох үйл ажиллагааны үед тоосжилт бий болох	Агаарын бохирдол болон орчины бохирдлыг хэмжих дотоод хяналтын багаж хэрэгсэлтэй болох	Уурхайн талбайд	500.0		4сар-10 сар дуустал	MNS4585:2016
	Гүний ус	- Чулуу олборлох талбай болон ажилчдын хотхон нь усыг төлөвлөгөөний дагуу бус хэтрүүлэн хэрэглэснээс гүний усны нөөц хомсдох - Шатах тослох материалыг алдснаар хөрсийг бохирдуулснаас газрын доорхи ус бохирдох	- Усны тоолуур бүхий төхөөрөмж суулгах, баталгаажуулах - Усыг дахин ашиглах, хуримтлуулах - Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах https://hsct.mn/ - Өдөр болгон шалгах, хуваарь хяналтын дэвтэр гаргах	Уурхайн хэмжээнд	1000.0		6сард	Усны тухай хууль MNS 2662-2002
	Хөрсөн бүрхэвч	Шатах тослох материал асгарах, гэнэтийн болзошгүй аваар осолоос үүдэн хөрсөн	Хөрсөн бүрхэвчийг талхагдахаас сэргийлж олон салаа зам үүсгэхгүй байх,	Уурхайн талбайд	500.0		4сар-10 сар дуустал	MNS “5917:2008”

СҮХБААТАР АЙМГИЙН ЭРДЭНЭЦАГААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨНДЛӨНГИЙН ӨНГӨЛГӨӨНИЙ БОРЖИН ЧУЛУУНИЙ ОРД”-ЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
		бүрхэвчийг бохирдуулах Шимт хөрсний овоолго үүсгэсний дараа хөрс сийрэгжсэн байх тул хөрс салхинд хийсэх, үерийн усанд урсан магадлалтай	нэгдсэн замын хөдөлгөөний сүлжээ зураг самбар тавих - ШТС агуулахын урьд хайрга дайрга асгаж хөрсөн бүрхэвчийг хамгаалах, хатуу хучилттай болгох. - Өнгөн хөрсийг хуулан авах уурхайн үйл ажиллагаа эхлэх үед өнгөх хөрсийг хуулж шимт хөрсийг овоолох					
	Ургамлан нөмрөг	Уурхайн үйл ажиллагаанаас ургамалан бүрхэвч доройтох	Жил бүр ургамлын судалгаа мониторинг явуулах, нөхөн сэргээлт хийхэд тохиромж үрийг орон нутгаас худалдан авах, үрийг түүх	Уурхайн талбайд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан Урсгал зардлаар		9-10сард	MNS 5918:2023
	Амьтны аймаг	- Уурхайн ухааш болон уурхайн талбайд зэрлэг амьтад нэвтрэх, улмаар нүх рүү унаж гэмтэх, хог хаягдлаас хордох - Нөхөн сэргээлтийг журмын дагуу хийгээгүйгээс амьдрах орчин доройтох - Уурхайн ажилчид хууль бусаар амьтан агнах үйлдэл гаргах	- Ажилчдад амьтны тухай хууль, байгаль хамгаалах талаар сургалт хийж байх - Ажилчдын тосгонд галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэглэхийг хориглох	Уурхайн талбай, бутлах үйлдвэрийн орчимд	Урсгал зардлаар		6сард	Амьтны тухай хууль

СҮХБААТАР АЙМГИЙН ЭРДЭНЭЦАГААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨНДЛӨНГИЙН ӨНГӨЛГӨӨНИЙ БОРЖИН ЧУЛУУНИЙ ОРД”-ЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Нийт						2000.0		

V.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Тэрбум мод тарих	Орон нутгаас төлөвлөсөн бүхий газар тарих	ширхэг	100	Дотоод төсөв	-	2025 оны 9 сард	-
2.	Биологийн нөхөн сэргээлт-шимт хөрс болон биологи	Шимт хөрсний овоолго хийх	га	-	-		4—10сард	MNS 5914: 2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
	Нийт					Дотоод төсөв		

V.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8
3	БОУАӨЯ	Хөв цөөрөм байгуулах	Орон нутгаас санал болгосон	1га	-	Дотоод төсөв	8-9сард	-
	Нийт					-		

V.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд хаваржаа, өвөлжөө байхгүй тул хамааралгүй болно.

V.5 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг авран хамгаалах ажлыг зохион байгуулсан болно. Хавсралтаар гэрээ болон тайлангийн дүгнэлтийг харуулав.

V.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Ажилчдад ХАБЭА-ны ажлын хувцас, малгай, хошуувч, гутал	Ажилчид	-	Дотоод төсөвд тусгасан		Өдөр бүр, тогтмол	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 2023-07-07 нэмэлт өөрчлөлт
		Гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Ажилчид	-	1000.0		Сургалтыг улирал бүрт 1 удаа	Галын аюулгүй байдлын тухай хууль 2015.12.04 нэмэлт шинэчилсэн найруулга
	Нийт					1000.0		

V.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хог хаягдлыг хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж хаях, түр хадгалах хог хаягдлын цэгийн газрын гадаргууг цементлэх	Хог хаягдлын ангилсан цэгийг засч тохижуулах	-	300.0		300.0	6 сард	Хог хаягдлын тухай шинэчилсэн хууль 2017.05.12 Агааржуулалттай сайжруулсан нүхэн жорлон Өрхийн нүхэн жорлонгийн MNS 5924:2015
2.	Шингэн	Шингэн хог хаягдлыг зайлуулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Цаг хугацаанд бохир зайлуулах гэрээний дагуу зайлуулах		500.0		500.0	Сар бүр	
	Нийт						800.0		

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэрээр нь барилгын болон ажилчдын буюу ахуйн гэж хоёр ангилна. Шинж чанараар нь хатуу, шингэн, хий гэж хувааж болно.

Төслийг хэрэгжүүлэх явцад барилгын ажилчдын түр суурин байгуулах ба үүсэн гарах ахуйн хог хаягдлыг дараах журмаар зохицуулна. Ялгаатай гурван өнгийн хог ангилан цуглуулах савыг барилгын ажилчдын түр сууринд байрлуулна. Доорх хүснэгт үзүүлсэн хаяг болон зааврыг сав бүрд байрлуулна. Эдгээр саванд хогийг зааврын дагуу ангилан хийж байгаа эсэхэд тухайн төслийн байгаль орчин эсвэл эрүүл ахуйн мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.

	Өнгийн шил, гэрлийн шил, толь, цонхны болон бусад шил хийхийг хориглоно!!!!
	Цаас болон бусад сонин сэтгүүл, цаасан хайрцаг, уут гэх мэт цаасан бүтээгдэхүүн, ус үл нэвтрүүлэх хайрцгууд. Эдгээрийг хогийн саванд хийхийн өмнө хавтгайлж нугалж хийнэ!!!
	Төмөр, хуванцар сав, баглаа боодол болон хуванцар сав хийнэ. Резин болон гялгар эдийг хийхгүй!!!

Зураг 3. Хогийн савны төрөл

Хогийн саванд тавигдах шаардлага: (Хог хаягдлын тухай хууль)

15.1.1.хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;

15.1.2.галд тэсвэртэй материалаар хийгдсэн;

15.1.3.хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

Хог хаягдал түүнийг цэвэрлэх, зайлуулах болон зохицуулах хэлбэр:

- Хог хаягдлыг орон нутгийн нэгдсэн хогийн цэгт нийлүүлэх талаар гэрээ байгуулж, холбогдох татвар хураамжийг цаг хугацаанд төлөх
- Ангилсан хог хаягдлаас боломжтой хэсгийг хоёрдогч түүхий эдийн цэгүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тогтмол тушаана.

- Барилгын ажлыг гүйцэтгэх явцад гарах хатуу хог хаягдлыг мөн түр цуглуулах цэгийг байгуулж хамгаалалтын хашаа, бункерт хийнэ. Ингэхдээ хууль, журмын дагуу энгийн, хяналттай, аюултай шинж чанараар нь ангилж хадгална. **Үүнийг хог хаягдал тээвэрлэх, устгах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тушааж байна.** Төслийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн хог хаягдлыг тушаасан талаарх тэмдэглэлийг тогтмол бүртгэнэ.
- Шатах тослох материалын сав, ахуйн цэвэрлэгээ, ариутгалын бодисын сав, баглаа боодлыг мөн тусад нь цуглуулна.
- Шингэн хаягдал болон бохирын асуудлыг Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2015 стандартын дагуу бохирыг соруулж зөөвөрлөх боломжтой байхаар зохион байгуулах
- Бохирыг соруулах, зөөвөрлөх эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажиллах.

V.8 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1. Агаарын чанар					
1.1	Тоосонцор- TSP / их эзлэхүүний арга/	2 цэгт 1 удаа	Агаарын найрлага: 6,9 саруудад	Гэрээт байгууллагаар хийлгэх 1жилд нийт 120.0	- MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, - MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, - MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
1.2	Агаарын найрлагыг тогтоох хэмжилт		Тоосны хяналт: - Олборлолтын талбайд - Хүнд даацын машины дотоод замд 6,9 саруудад	Гэрээт байгууллагаар хийлгэх 1жилд нийт 120.0	

СҮХБААТАР АЙМГИЙН ЭРДЭНЭЦАГААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨНДЛӨНГИЙН ӨНГӨЛГӨӨНИЙ БОРЖИН ЧУЛУУНИЙ ОРД”-ЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

					- MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
2. Усны хяналт шинжилгээ					
2.1	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	Жилд 4 удаа 3,6,9,12 саруудад	32.0*4 удаа 1жилд нийт 130.0	- MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж - MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага - MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж - MNS 13.060.50 Усны чанарын стандарт - MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3. Хөрсний бохирдол					
3.1	Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайд 2 цэг сонгох /Овоолго болон олборлолт явуулж буй талбайн ойролцоо/	- Жилд 2 удаа - 6, 9 саруудад	1 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1жилд нийт 126.0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж -хүнд металлын шинжилгээ 1 дээж	- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, - MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга - MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга - MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4. Цацрагийн хяналт шинжилгээ					

*СҮХБААТАР АЙМГИЙН ЭРДЭНЭЦАГААН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨНДЛӨНГИЙН ӨНГӨЛГӨӨНИЙ БОРЖИН ЧУЛУУНИЙ ОРД”-ЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*

4.1	Боржин чулууны дээж дээр цацрагийн хяналт шинжилгээ хийлгэх	Боржин чулуунаас	- Жилд 1 удаа	Дотоод төсөв	
5. Хэмжилт дээжлэлтийн зардал					
5.1	Хэмжилт дээжлэлтийн зардал		-	8 дээж 1000 .0	
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖИЛИЙН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН				1496.0	

V.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв Мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
	1	2	3	4	5
1	Газрын хянан баталгаа хийлгэх	Дотоод төсөв	2025 онд хийлгэх	ХАБЭА	-

**V.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах
төлөвлөгөө**

№	БОМТ, хэрэгжилтийг оролцогч талууд	БОМТ-ний тайлагнахад хэлбэр	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан байгуулах тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7	
1.	2025 оны БОМТ-ны дагуу танилцуулах	Цаасан	Тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Жил бүрийн 11 сар	-	Байгаль орчны мэргэжилтэн	БОУАӨЯ	
2.	2025 оны БОМТ-ны дагуу хэрэгжилтийг тайлагнах	Цаасан,	Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг батлуулах	Жил бүрийн 11,12 сар	-	Байгаль орчны мэргэжилтэн	БОУАӨЯ	
	Нийт				-			

V.11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгт 7Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,000,000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Дотоод төсөв
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	4,000,000.0
4	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1,000,000.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	800,000.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,496,000.0
7	БОМТ-г хэрэгжүүлэх тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
8	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
Нийт		9,296,000.0

“Бичигт шим майнинг” ХХК-ний Хөндлөнгийн өнгөлгөөний боржин чулууны ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2025 онд нийт 9.296 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын тоот тушаал, 2019 он
6. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2024 он
7. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ыг ашиглах ТЭЗҮ 2024 он
8. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ыг ашиглах 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө
9. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ыг ашиглах 2024 оны батлагдсан уулын ажлын төлөвлөгөө
10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014 он
11. <http://www.legalinfo.mn>